



# СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№61 /505/

2023.04.14

Цаг үе, үйл явдал

## “ЕРӨНХИЙ ЦЭРГИЙН МЭРГЭЖЛИЙН ӨДӨР”- ИЙГ УГТАЖ ...



Жил бүрийн 5 дугаар сарын 14-ний өдөр тохиодог “Ерөнхий цэргийн мэргэжлийн өдөр”-ийг угтан Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалаас залуу офицер, ахлагч нарыг мэргэжлээрээ бахархаж, мэдлэг, ур чадвараа нэмэгдүүлэхэд нь чиглэсэн хэд хэдэн арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлж байна.

Үүний нэг нь Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын салаа, ротын түвшинд тактикийн бүлгүүдээр байлдааны ажиллагааг зохион байгуулах чадварыг нэмэгдүүлэх, албан тушаалтнуудын тактикийн сэтгэлгээг хөгжүүлэх, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, Хуурай замын цэргийн мэргэжлийг сурталчлах

зорилготой “Тактикийн олимпиад-2023” уламжлалт тэмцээн юм.

Ес дэх жилдээ зохион байгуулагдах энэхүү тэмцээнд батальон /дивизион/-ы захирагч хүртэлх албан тушаалтнууд нас, мэргэжил харгалзахгүйгээр хоёр үе шаттайгаар оролцоно.

Нэгдүгээр шатад нэгтгэл, ангиасаа хоёр тэргүүний алба хаагчаа тодруулах бол хоёрдугаар шат нь 5 дугаар сарын 12-14-ний өдрүүдэд Хуурай замын цэргийн командлал болон хээрийн хичээлийн байрлалд онол болон дадлагын хэлбэрээр явагдах юм. Уралдааныг Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлал, “Ерөнхий цэрэг ассоциаци” ТББ хамтран зохион байгуулна.

Ташрамд онцлоход, 2022 оны “Тактикийн олимпиад”-д Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл, Зэвсэгт хүчний 256, 350 дугаар ангийн офицерууд эхний гурван шагналт байр, Зэвсэгт хүчний 150, 123 дугаар ангийн алба хаагчид тусгай байрт шалгарч байсан билээ.

Мөн Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалаас алба хаагчдын англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх, гадаадын сургууль, дамжаа, НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэхээр бэлтгэгдэж байгаа цэргийн алба хаагчдад дэмжлэг үзүүлэх, гадаад хэл сурах хүсэл эрмэлзлийг идэвхжүүлэх зорилгоор Хуурай замын цэргийн нэгтгэл, ангиудын бүрэлдэхүүний дунд “Англи хэлний олимпиад-2023” тэмцээнийг 4 дүгээр сарын 26-ны өдөр зохион явуулна.

Олимпиадад хугацаат болон цэргийн гэрээт алба хаагч, ахлагч, офицер аль нь ч оролцох боломжтой ба тэднийг унших, бичих, сонсох, орчуулах чадвараар нь өрсөлдүүлэх ажээ.

## ХӨДӨЛГӨӨНТ БҮЛГЭЭР ЖОЛООНЫ ҮНДСЭН БОЛОН АНГИЛАЛ АХИУЛАХ СУРГАЛТЫГ ЯВУУЛЖ ЭХЭЛЛЭЭ



БХЯ, ЗХЖШ-аас хэрэгжүүлж байгаа нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх ажлын хүрээнд Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарын офицер, ахлагч, гэрээт болон ХЦАХ-дын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, алба хаагчдын ар гэрийг дэмжих зорилгоор ЗХЖШ-ын даргын тушаалаар

Зэвсэгт хүчний 011 дүгээр анги жолооны А, В ангилал, бусад ангилал ахиулах сургалтыг 40 хувийн хөнгөлөлтэй үнээр явуулж байна.

Уг сургалтын чанар, хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор ЗХЖШ-аас Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн материаллаг баазыг бэхжүүлж төрөл бүрийн ангиллын жолоодлого хийх машины тоог нэмэгдүүлж, суудлын авто машин 4 нэгж, траллер 1 нэгж, экскаватор 1 нэгж, хуягт тээвэрлэгч БТР-60 1 нэгжээр хангасан. Ингэснээр тус анги үндсэн сургалттай зэрэгцэн хөдөө орон нутагт сургалтын хөдөлгөөнт бүлгийг нэмэлтээр ажиллуулах боломж бүрдсэн юм.

Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн Техникийн бага мэргэжилтэн бэлтгэх сургалтын төв тус жолооны сургалтыг

Зэвсэгт хүчний тээврийн хяналтын алба, Цагдаагийн ерөнхий газрын бүртгэл хяналтын төвтэй хамтран энэ сарын 10-ны өдрөөс эхлэн Улаанбаатар цэргийн хүрээний ангиудын бүрэлдэхүүнийг Зэвсэгт хүчний 011 дүгээр анги, Тусгай хүчний командлалын харьяа ангиудын бүрэлдэхүүнийг 150 дугаар ангийн байрлалд нэгтгэн үндсэн бүлгээр, Өмнөговь аймаг дахь Зэвсэгт хүчний 167, Баян-Өлгий аймаг дахь Зэвсэгт хүчний 340 дүгээр ангиудад хөдөлгөөнт бүлгээр сургалт явуулж байна.

Энэхүү сургалт нь ЗХЖШ-ын даргын тушаалаар 2022 оны 12, 2023 оны 02 дугаар саруудад явагдсан сургалтын үргэлжлэл бөгөөд одоогоор Зэвсэгт хүчний 300 гаруй алба хаагч, ар гэрийн гишүүдийг хамруулаад байгаа юм.

**Хошууч Ж.ТӨГСМАНДАХ**



### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 5	☁️ -9

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 39	☁️ 26

### ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,492	3,503
EUR 🇪🇺	3,850	3,870
CNY 🇨🇳	511	513
RUB 🇷🇺	42	42.70
JPY 🇯🇵	26.50	26.80
KRW 🇰🇷	2.67	2.70

### ЗУРХАЙ



2023.04.14 /БААСАН ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 24

**ХАВРЫН ДҮНД ХӨХӨГЧИН ТУУЛАЙ САР ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ ХАР БАР ӨДӨР**

Үс засуулбал:

Өвчин эмгэг ирнэ  
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:  
06.08-19.38

Барилдлага:

Шид  
ШҮТЭН БАРИЛДЛАГА:  
Хурьцахуй

Тухайн өдөр хонь, бич, тахиа, могой, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр аливаа үйлс сэтгэлчлэн бүтнэ. Шүтээн босгох, хот балгадыг барих, тариа тарих, худалдаа наймаа хийх, шид бүтээл үйлдэх тарни тоолох болон дэлгэрүүлэх үйл бүхнээ сайн болой, бурханы үйл, хувцас хийхэд сайн. Зүүн нүд татвал хувцас олох, баруун чих цангинавал үзэсгэлэн болох, зүүн нь бол үхэл болсныг сонсох, нохой уливал сонсголонттой үг сонсох, тагнай загатнавал гэр арвидах, бие татвал 1-2 хүн ирэх, хөл татвал гомдол аюул болно.

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 685,396,069

Эдгэрсэн

Нийт: 658,142,801

Нас барсан

Нийт: 6,841,124

Цахим шууданд

## УЛАМЖЛАЛТ “МУЗЕЙЧИД ЦЭРГИЙН АЛБАНД” ТАНИН МЭДЭХҮЙН АЯЛАЛ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА



Олон улсын музейн өдрийг 1977 оноос жил бүрийн 5 дугаар сарын 18-ны өдөр дэлхий дахинд уламжлал болгон тэмдэглэж эхэлсэн бөгөөд Монгол Улс анх 1998 онд Олон улсын музейн өдрийг тэмдэглэж эхэлсэн байна.

Энэхүү өдөр дэлхийн олон орны музейнүүд нэгэн урианы доор нэгдэж Олон улсын музейн өдрийг тэмдэглэн өнгөрүүлдэг бөгөөд олон нийтэд чиглэсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулдаг уламжлалтай.

Энэ удаагийн олон улсын музейн өдрийг угтан Монгол цэргийн музейгээс уламжлалт арга хэмжээ болох цэргийн анги, салбарын үйл ажиллагаатай танилцах, цэргийн албаны онцлог, хугацаат цэргийн алба

хаагчдын өдөр тутмын цагийн хуваарьт ажиллагааг үзэх, цэргийн ахуйд зочлон биеэр мэдрэх боломж олгодог “Музейн ажилтнууд цэргийн албанд” танин мэдэхүйн аяллыг Зэвсэгт хүчний 311 дүгээр ангид зохион байгууллаа.

Аялалд Монгол цэргийн музей, Олон улсын музейн зөвлөлийн Монголын хороо, Байгалийн түүхийн музей, Соёлын Өвийн Үндэсний төв, Чойжин ламын музей, Дүрслэх урлагийн музей, Улаанбаатар хотын музей, Угсаатны зүйн хувийн музей зэрэг музейнүүдийн төлөөлөл 20 гаруй төлөөлөл хамрагдлаа.

Энэхүү танин мэдэхүйн аяллаар Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төв, Энхийг дэмжих ажиллагааны сургалтын төвөөр зочлон олон улсын

хамтарсан сургалт дадлага, төрөл бүрийн мэргэжлийн сургалт, “Цэргийн олимп” хэмээн нэрлэгддэг марш тактикийн тэмцээн явагддаг газар орон болон тус ангийн нэг өдрийн үйл ажиллагаа, офицер, ахлагч, түрүүч, байлдагч нарын сургалт бэлтгэл, чөлөөт цагаа хэрхэн өнгөрөөдөг тухай мэдээлэл авч, сонирхолтой аялал хийсэн юм. Мөн тус ангийн Соёлын төв, Цэргийн гал тогоо, НҮБ-ын стандартын эмнэлэг, Биеийн тамирын заал зэрэг нь нийт алба хаагчдын ажиллаж, амьдрах бүхий л боломжийг бүрдүүлсэн байгааг музейн төлөөлөл бахархан ярьж эр цэрэг, цэргийн албаар бахархан, тэдний ажлын онцлог, ололт амжилтыг харж хавраар очсон хүмүүс өвлийн цасан шуурга, салхи жавар зэргийг нэгэн зэрэг үзэж ёстой л “цэргийн хүн” болохоо шахав.

Тэрчлэн энэхүү аяллын бүрэлдэхүүн Зэвсэгт хүчний Зенитчдийн нэгдсэн сургалт дадлага буюу харвалтыг үзэж сонирхон дарийн утаа үнэрлэсний зэрэгцээ цэргийн нормт хоолыг амтархан зооглосон нь нэгэн мартагдашгүй дурсамж үлдээсэн үйл явдал боллоо. Ийнхүү “Музейн ажилтнууд цэргийн албанд” үйл ажиллагаанд идэвхтэй оролцон нэгэн өдрийг бидэнтэй хамт өнгөрүүлсэн Та бүхэнд Монгол цэргийн музейн удирдлага хамт олны зүгээс талархал илэрхийлье.

Бэлтгэл дэд хурандаа Л.ГАНТӨМӨР

## ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ЁС ЗҮЙН АСУУДЛААР СУРГАЛТ ЯВУУЛАВ



ШШГЕГ-ын харьяа 441 дүгээр нээлттэй хорих ангийн дарга хурандаа Ч.Мөнх-Эрдэнийн урилгаар ЗХЖШ-ын Захиргааны удирдлагын газрын Хэвлэл мэдээллийн албаны дарга хурандаа Б.Отгонбаяр тус ангийн бие бүрэлдэхүүнд лекц уншиж, харилцан ярилцлага зохион байгуулав.

“Цэргийн алба хаагчийн ёс зүйн төлөвшил”, “Эх оронч үзэл, хүмүүжлийн зарим асуудлууд”, “Цэргийн нийтлэг дүрмүүдийг

үйл ажиллагаандаа бүтээлчээр хэрэгжүүлэхэд албан тушаалтнуудын үүрэг” сэдвийн хүрээнд уг сургалтыг явуулсан юм.

Энэ үеэр тус ангийн офицер, ахлагч нартай хэд хэдэн чиглэлээр харилцан ярилцлагыг өрнүүлсний зэрэгцээ өөрийн уран бүтээлээсээ урлагийн мэндчилгээ дэвшүүлсэн нь тэдний талархлыг хүлээв.

Хошууч Э.ГАНБАЯР

## АГААРЫН ЦЭРГИЙН ДАРГАЛАХ АЛБАН ТУШААЛЫН АХЛАГЧ НАР ЧУУЛЛАА



Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагчийн тушаалаар даргалах албан тушаалын ахлагч нарын цугларалтыг энэ сарын 13,14-ний өдрүүдэд Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн материаллаг баазыг түшиглэн зохион байгуулж байна.

“Зэвсэгт хүчний Агаарын цэргийн даргалах албан тушаалын ахлагч нарын манлайлал, сургалт бэлтгэл” сэдвээр зохион байгуулагдаж байгаа уг сургалтад Агаарын цэргийн анги, байгууламж, тусгай ротуудын даргалах албан тушаалын ахлагч оролцож байна.

Сургалтыг Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч хурандаа Т.Ганбат нээж үг хэлсэн бөгөөд цугларалтад оролцогчдод амжилт хүсэн, энд сурсан мэдсэн, сонссон зүйлээ өөртөө авч үлдэх биш

анги тус бүрдээ очоод ажил болгон хэрэгжүүлж, манлайллыг, үлгэрлэлийг өөрөөсөө эхлүүлэхийг уриалсан юм.

Цугларалтаар Зэвсэгт хүчний ахлагчийн албаны өнөөгийн байдал ба хөгжлийн хандлага, Байлдааны жижүүрлэлтийн үүрэг гүйцэтгэдэг ахлагч нарт тулгамдаж буй асуудал, Ахлагчийн бүрэлдэхүүний албанаас чөлөөлөгдөж байгаа шалтгаан, тэдгээрийг бууруулах арга замыг эрэлхийлэх нь сэдвийн хүрээнд эхний өдөр хэлэлцсэн бол хоёр дах өдөр Улаанбаатар их сургуулийн гэр бүл судлалын тэнхимийн эрхлэгч, доктор Б.Оюун-Эрдэнийг урьж “Хувь хүний манлайлал, Байгууллагын манлайлал” сэдвээр ярилцаж, санал солилцлоо.

АХМАД Л.САРАНЗАЯА

## СЭЛЭНГЭ АЙМАГ АНХ УДАА "ОЮУТАН ЦЭРЭГ" ЦЭРГИЙН ЕРӨНХИЙ БЭЛТГЭЛ ШАТНЫ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙНА



Монгол Улсын Цэргийн албаны тухай хууль, Засгийн газрын 2017 оны 32 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Батлан хамгаалах сайдын 2023 оны дугаар тушаалаар “Оюутан цэрэг” сургалтыг Сэлэнгэ аймаг анх удаа зохион байгуулж байна. Энэ жилийн “Оюутан цэрэг” сургалтад тус аймгийн Мандал сумын Зүүнхараа Политехникийн

коллежийн 10 оюутан хамрагдаж байна.

Сургалтын нээлтийн үйл ажиллагаанд Зүүнхараа Политехникийн коллежийн захирал Ц.Эрдэнэчулуун, Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дэд хурандаа М.Ганбат, багш, сурагчид болон эцэг, эхчүүд оролцлоо.

Оюутан цэрэг сургалтад хамрагдах оюутнууд 2023 оны

04 дүгээр сарын 08-ний өдрөөс 06 дугаар сарын 03-ний өдөр хүртэл бямба, ням гарагт Зүүнхараа Политехникийн коллежийн “Хичээлийн танхим”-д “Цэргийн ерөнхий бэлтгэл” шатны сургалтад хамрагдах бөгөөд 06 дугаар сарын 15-ны өдрөөс 08 дугаар сарын 15-ны өдөр хүртэл Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн сургалтын нэгдсэн төвд “Цэргийн мэргэжлийн бэлтгэл” шатны сургалтад хамрагдах юм.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗДТГ-ЫН ЦЭРГИЙН ШТАБ

